

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар
(2025 оны эхний хагас жил)

2025.06.19

Чойбалсан хот

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
МУ-ын хууль							
	53		1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.	Бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх ажлын хүрээнд 18 удаагийн арга хэмжээг зохион байгуулж идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэгч 6,137 иргэдийг хамруулсан. Биеийн тамир спортын газрын дэргэдэх “Хаан банк 3Х3” сагсан бөмбөгийн талбайг засварлаж Хэрлэн сумын хөрөнгө оруулалтаар найрамдал паркт сагсан бөмбөгийн 3х3, 5х5 талбай, Гоёмсог алхаа бүжгийн клуб, 9-р багт чавх харвааны төвүүд шинээр нээгдэн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж байна. 2025 онд Биеийн тамир спортын газрын үйл ажиллагаанд 890 сая төгрөг батлагдсан нь 2024 оныхоос 5,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.		Хэрэгжсэн	
40	85	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Хүүхэд залуусыг спортоор тогтмол, тогтвортой хичээллүүлж байгаа спортын холбоо, клубэд дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд: Волейболын 3 удаагийн аймгийн аварга “Хувьсал” багийг улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж 500 мянган төгрөг Сагсан бөмбөгийн охидын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон “12 team” багт 500 мянган төгрөг Волейболын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээний хөвгүүдийн ангилалд оролцсон “Хэрлэн барс” клуб-д 1,500,000 мянган төгрөг Мини волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Аймгийн волейболын холбоотой хамтын		Хэрэгжсэн	

				ажиллагааны хүрээнд нээлттэй тэмцээнийг хамтран зохион байгуулсан байна.			
	265		1.13. 1.13. Аймаг, нийслэлийн хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлэх, биеийн тамирын дасгал сургуулилтаар хичээллэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх;	Иргэдийг спорт дасгал хөдөлгөөнөөр хичээллэх таатай орчин нөхцөл боломжоор хангах, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, зорилгоор Биеийн тамир спортын газарт Волейболын 12-14, 15-16 насны охидын шигшээ баг 96 удаа 144, 192 цагийн бэлтгэл сургалтыг зохион байгуулж 40 тамирчин, Хөлбөмбөгийн анхан шат сургалтыг 63 удаа 94,5 цаг, 14, 16 насны хөвгүүдийн шигшээ багийн бэлтгэл сургалт 84 удаа 168 цагийг зохион байгуулж 25 тамирчин, Бадминтоны өсвөрийн шигшээ баг 18 хүртэл насны тамирчдад 63 удаагийн нийт 94,5 цагийн бэлтгэл сургалтыг зохион байгуулж хөвгүүдийн 29, охидын 25 нийт 54 тамирчин, Сагсан бөмбөгийн 13, 14, 17 насны шигшээ багийн бэлтгэл сургалтанд нийт 147 удаагийн 294 цагийн бэлтгэл сургалтыг зохион байгуулж 40 тамирчин, Хөнгөн атлетикийн өсвөрийн тамирчдын 140 удаагийн 288 цагийн бэлтгэл сургалтыг төлөвлөж, бэлтгэл сургалтад 15 хүртэлх насны 22 тамирчин, 17 хүртэлх насны 24 тамирчид тус тус хамрагдсан		Хэрэгжсэн	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС